

**МОНГОЛ УЛС: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САР
ТУТМЫН ТОЙМ**

2015.07

Үзүүлэлтүүд:

ДНБ-ний өсөлт 3%	ГШХО 6-р сард 65.6 сая ам.доллар	Төсвийн тэнцэл (637.8) тэр бум төгрөг	Инфляци 6.9%	Чанаргүй зээл 824.6 тэрбум төгрөг	Валютын нөөц 1.69 тэрбум ам.доллар
Өсөлтөнд ХАА салбар 9.2%, аж үйлдвэр, барилгын салбар 12.1%, үйлчилгээний салбар 3%-иар тус тус өссөн нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 5-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18 сая ам.доллараар өсч, өмнөх сараас 8.9 сая ам.доллараар буурч 28.4 сая ам.доллар болов.	Төсвийн орлого 3.14 их наяд төгрөг, зарлага 3.78 их наяд төгрөг болж тэнцэл 637.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.	Өмнөх сараас өөрчлөлтгүй, оны эхнээс 3.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.9 хувиар өслөө.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 50.7 тэрбум төгрөг буюу 6.6%-иар өсч 824.6 тэрбум төгрөгт хүрэв.	Монголбанкны валютын нөөц өмнөх сараас 5.9 хувь буюу 95 сая ам.доллараар өсч 1686 сая ам.долларт хүрэв.



Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш

1978.28



Орон сууцны үнийн индекс

1,123

Өмнөх сараас 1.491%-иар, өмнөх жилээс 10.234%-иар тус бүр буурлаа.



Монголбанкны бодлогын хүү

13%




Тулгар төрийн 2224, Их Монгол Улсын 809, Ардын хувьсгалын 94 жилийн ой, Үндэсний их баяр наадам долдугаар сарын 11-15-ны өдрүүдэд өргөн, дэлгэр болж өндөрлөв.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, оны эцсийн байдлаар хүснэгтээр үзүүлээ.

Эх сурвалж: ҮСХороо



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд (Мянган ам.доллар, тонн)

Голлох бүтээгдэхүүн	2012 он		2013 он		2014 он	
	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар	Тонн	Ам.доллар
Чулуун нүүрс	20574	1 880 396	18 194	1 116 153	1 106	850 615
Төмрийн хүдэр	6415	532 509	6725	654 333	8 338	448 378
Зэсийн баяжмал	575	838 780	650	948 951	1 378	2 575 636
Нийт	27564	3 251 685	25 569	2 719 437	10 822	3 874 629

Эх сурвалж: ҮСХороо

Монгол Улсад анхны чөлөөт сонгууль явагдсаны 25 жилийн ойн баярын “Бүрэн эрхт байдлын өдөр”-ийг долдугаар сарын 29, 30-ны өдрүүдэд орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ.


ДНБ

ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний хагас жилд 7.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 205.6 тэрбум төгрөг буюу 3 хувиар өслөө. Үүнд ХАА-н салбар 9.4 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 12.1 хувь, үйлчилгээний салбар 3 хувиар тус тус өссөн нөлөөлжээ.



Төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 7-р сард 3.14 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх зээлийн хэмжээ 3.78 их наяд төгрөг, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 637.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 476.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Төсвийн орлогын 87.3% татварын, 12.6% татварын бус, 0.1% тогтворжуулалтын сангийн орлого эзэллээ.




Валютын ханш

Долдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 1978.28 төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 134.21 төгрөг буюу 7.3 хувь, өмнөх сараас 74.98 төгрөгөөр буюу 3.9 хувиар тус тус суларчээ.



Инфляци


Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2015 оны 7-р сард өмнөх сарынхтай харьцуулахад өөрчлөлтгүй, оны эхнээс 3.3%, өмнөх оны мөн үеийнхээс 6.9% өслөө. Индекс оны эхнээс 3.3%-иар өсөхөд 67.4% нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн өсөлтөөс, 18.7% нь хувьцас, бөс бараа, гутлын бүлгийн өсөлтөөс шалтгаалсан байна.



* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УСХ, МБ

Гадаад валютын нөөц


Гадаад валютын улсын албан нөөц 2015 оны зургаадугаар сарын байдлаар 1,686 сая ам.доллар байв. Энэ нь өмнөх сараас 5.9% буюу 95 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 28 хувь буюу 369 сая ам.доллараар, оны эхнээс 2.2% буюу 36 сая ам.доллараар тус тус өссөн байна. Валютын нөөц сүүлийн 2 сар дараалан өсөөд байна.



* Эх сурвалж Монголбанк

MSE-20 индекс

Үнэт цаасны арилжаагаар 2015 оны 7-р сард 635.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 21.6 сая ш үнэт цаас арилжигдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 500.3 тэрбум төг буюу 4.7 дахин өсч, арилжигдсан үнэт цаас 11.3 сая ш буюу 34.3% буурсан байна. ТОП-20 дундаж индекс тайлант сард 14219 нэгж болж, өмнөх сарынхаас 372.2 нэгжээр буурчээ. Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа ХК-иудын үнэт цаасны нийт үнэлгээ 1.3 их наяд төгрөг болов.



*Монголын хөрөнгийн бирж


Монго

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2015 оны 7-р сард 9.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 177.9 тэрбум төгрөг буюу 1.8%, өмнөх оны мөн үеэс 214.8 тэрбум төгрөг буюу 2.1%-иар тус тус буурчээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө тайлант сард 759.0 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 3.2 тэрбум төгрөг буюу 0.4%-иар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 100.6 тэрбум төгрөг буюу 11.7%-иар буурсан байна.



Хадгаламж

Нийт хадгаламж 2015 оны 7-р сард сард 7.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 117.2 тэрбум төгрөг буюу 1.6 хувиар буурчээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 78.6 тэрбум төгрөг буюу 1.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү өмнөх сараас нийт хадгаламж буурахад төгрөгийн хадгаламж 2.6 хувиар буюу 139.9 тэрбум төгрөгөөр бууж, валютын хадгаламж 1.1 хувиар буюу 22.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ



Зээл

ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2015 оны 7-р сарын байдлаар 12.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 45.2 тэрбум төгрөг буюу 0.4%-иар өсч, өмнөх оны мөн үеэс 232.6 тэрбум төгрөг буюу 1.9%-иар буурчээ. Харин чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 824.6 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 6.6% (50.7 тэрбум төгрөг)-иар, өнгөрсөн оны мөн үеэс 37.5% (224.9 тэрбум төгрөг) өссөн байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6.9%-ийг эзэлж байна.



Ипотекийн зээл

2015 оны 6-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 2 хувь (64.2 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 30.8 хувь (752 тэрбум төгрөг) - иар нэмэгдэж нийт 3.19 их наяд төгрөгт хүрэв. Зуравдугаар сард нийт 1567 зээлдэгчид 100.2 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 72412-д хүрлээ. Ипотекийн зээлийн үлдэгдлийн 98.3 хувь нь төгрөгийн, 1.7 хувь нь гадаад валютын зээл байгаа бөгөөд нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээл 0.5 хувийг эзэлж байна




* Эх сурвалж Монголбанк

Гадаад худалдаа

Гадаад худалдаа


2015 оны 7-р сард худалдааны нийт бараа эргэлт 5021.7 сая ам.доллар, үүнээс экспорт 2812.8 сая ам.доллар, импорт 2208.8 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 604.0 сая ам.долларын ашигтай гарлаа. Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 127.1 сая ам.доллар буюу 4.3%-иар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 199.6 сая ам.доллар, нэхмэл бүтээгдэхүүнийх 24.8 сая ам.доллараар буурсан нь нөлөөлсөн бол импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 915.7 сая ам.доллар буюу 29.3%-иар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 278.0 сая ам.доллар, усан замын тээврийн эд ангийнх 192.1 сая ам.доллар, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 178.1 сая ам.доллар, үндсэн төмөрлөг бүтээгдэхүүнийх 179.1 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөллөө.



* Эх сурвалж ҮСХ, МБ

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2015 оны 7-р сард гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 65.6 сая ам.долларт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 39.5 сая ам.доллараар өсч, өмнөх сараас 18.1 сая ам.доллараар буурсан үзүүлэлт юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтад МУ-аас гадаадруу гаргасан хөрөнгө оруулалт -0.7 сая ам.доллар байсан бол Монгол Улсад 66.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ. Сүүлийн гурван сар дарааллан хөрөнгө оруулалт эерэг дүнтэй гарч байгаа билээ.



* Эх сурвалж МонголБанк

Сарын онцлох үйл явдал

- 07.02** Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 7 дугаар сарын 2-ны өдөр хуралдаж, мөнгөний бодлогын хүүг өөрчлөхгүй хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.
- 07.09** УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон холбогдох бусад хуулийн төслүүдийг батлагдав. Уг хууль батлагдсанаар нэмэгдсэн өртгийн албан татварын босго 10 сая төгрөг байсныг 50 сая төгрөг болгож, татварын 2 хувийн буцаан олголт олгохоор болж байгаа бөгөөд энэхүү хуулийг 2016 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлнэ.
- 07.09-07.10** Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ОХУ-ын Уфа хотноо болж буй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн болон ажигчлагч орнуудын төрийн тэргүүн нарын өргөтгөсөн хуралдаанд оролцож, үг хэлэв. Мөн энэ үеэрээ Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нарын гурван талт уулзалт хийжээ.
- 07.29** Монгол Улсад анхны Ардчилсан чөлөөт сонгууль 1990 оны долдугаар сарын 29-ний өдөр болсон түүхэн үйл явдлыг тэмдэглэх зорилгоор жил бүрийн долдугаар сарын 29-ний өдрийг “Бүрэн эрхт байдлын өдөр” болгон тэмдэглэж байхаар Монгол Улсын Засгийн газраас тогтоолоо. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны зургаадугаар сарын 03-ны өдрийн захирамжаар энэхүү түүхэн үйл явдлын 25 жилийн ойн баярыг энэ сарын 29, 30-ны өдрүүдэд орон даяар тэмдэглэхээр болсон.

Тойм

ОХУ-ын Уфа хотноо болж буй Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн 15 дугаар хуралдааны хүрээнд Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Төрийн тэргүүн нарын хоёр дахь удаагийн ээлжит дээд түвшний уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү уулзалтын үеэр Гурван улсын Төрийн тэргүүн нарын хоёр дахь удаагийн уулзалтын үеэр талууд хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлэх 4 баримт бичгийг байгууллаа. Юуны өмнө Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хамтын ажиллагааг дунд хугацаанд хөгжүүлэх замын зураглалыг батлав. Энэхүү баримт бичиг нь гурван улсын улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон бүс нутаг, олон улсын харилцааны чиглэлээр хөгжүүлэх хамтын ажиллагааны цаашдын чиг хандлагыг тодорхойлсон чухал баримт бичиг юм. Монголын талын хүсэлтээр уг замын зураглалд гол төлөв худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар тодорхой тусгаж, манай хөрш орнуудын хоорондох худалдааны эргэлт нэмэгдэж байгаатай холбогдуулан Улаанбаатар төмөр замаар дамжин өнгөрүүлэх ачаа тээврийг нэмэгдүүлэх, улмаар Монгол-Орос-Хятадын төмөр замын тээвэр логистикийн компани байгуулах боломжийг судлахаар тусгасан болно. Түүнчлэн гурван улсын хооронд гадаад худалдааны үйл ажиллагааг хөнгөвчлөх ажлын хүрээнд үндэсний мөнгөн тэмдэгт ашиглах явцыг өргөжүүлэх худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагааны механизм байгуулах асуудлыг тусгав.